**МОНГОЛ УЛС**
**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2017 оны 05 сарын 26 өдөр Дугаар А/206 Хэрлэн сум

Голомтын ариутгал халдваргүйжүүлэлтийн ажлыг
зохион байгуулж, хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Малын удмын сан эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5.4, 6 дугаар зүйлийн 6.4.3, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.1, 58.2.17 дахь заалт, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2 дугаар зүйлийн 2.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Малын гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчний голомтыг таслан зогсоох зорилгоор шүлхий, хонины цэцэг, боом, галзуу өвчний голомтуудыг ариутгаж халдваргүйжүүлэх ажилд аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн малын гоц халдварт өвчинтэй тэмцэх сангаас гаргах зардлыг нэгдүгээр, Хүнс, хөдөө аж ахуйн газар, сумдын Засаг даргын Тамгын газраас гаргах зардлыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталж, үйл ажиллагааны зардалд 2079140 /хоёр сая далан есөн мянга нэг зуун дөчин/ төгрөгийг зарцуулсугай.

2. Голомтын ариутгал халдваргүйжүүлэлтийн зардлыг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн малын гоц халдварт өвчинтэй тэмцэх сангаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /С.Нямдаваа/-д, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Э.Мөнх-Эрдэнэ/-д тус тус даалгасугай.

3. Мал, амьтны гоц халдварт болон малаас хүнд халдварладаг зооноз өвчний голомтуудыг ариутгаж халдваргүйжүүлэх ажлыг 2017 оны 06 дугаар сарын 05-ны өдрөөс 2017 оны 07 дугаар сарын 05-ны өдрийг хүртэлх хугацаанд чанартай зохион байгуулж, мэргэжил арга зүйн заавар удирдлага, тусгай зориулалтын авто машин, тоног төхөөрөмж, шаардагдах эмийн бодис, халдвар хамгааллын хувцас хэрэгслээр хангаж, дүнг 2017 оны 07 дугаар сарын 10-ны дотор танилцуулахыг Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга /Ж.Энх-Амгалан/-д, ажлын явц, чанар, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газрын дарга /Б.Сүнгээ/-д тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА Н.ГАНБЯМБА

011010

D:\My Documents\Захирамж 2017.doc

Аймгийн Засаг даргын 2017 оны 05 дугаар сарын 26 өдрийн А/206 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

ГОЦ ХАЛДВАРТ, ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ГОЛОМТЫГ АРИУТГАЖ ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭХЭД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН НӨӨЦ САНГААС ГАРАХ ЗАРДЛЫН НЭГТГЭЛ.

| № | Сумын нэр | Ариутгах голомтын тоо | | | | | Сумаас голомт хооронд явах /км/ | Голомт ариутгах | | | Мотор ажиллуулах | | | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Боом | Галзуу | Шүлхий | Хонины цэцэг | Бүгд | | Шаардагдах шатахуун А-92 / л / | Нэг бүрийн үнэ | Бүгд үнэ | Шаардагдах шатахуун А-80 / л / | Нэг бүрийн үнэ | Бүгд үнэ | |
| 1 | Галшар | | 5 | 6 | 2 | **13** | 455 | 91,0 | 1710 | 155610 | 13 | 1640 | 21320 | 176930 |
| 2 | Баянхутаг | 8 | 17 | | 8 | **33** | 758 | 151,0 | 1700 | 256700 | 33 | 1540 | 50820 | 307520 |
| 3 | Дэлгэрхаан | 18 | 12 | | 12 | **42** | 440 | 88,0 | 1540 | 135520 | 42 | 1380 | 57960 | 193480 |
| 4 | Жаргалтхаан | 6 | 10 | | 2 | **18** | 247 | 49,0 | 1670 | 81830 | 18 | 1550 | 27900 | 109730 |
| 5 | Цэнхэрмандал | | 2 | | 13 | **15** | 432 | 86,0 | 1670 | 143620 | 15 | 1560 | 23400 | 167020 |
| 6 | Өмнөдэлгэр | 15 | 5 | | 6 | **26** | 335 | 67,0 | 1720 | 115240 | 26 | 1520 | 39520 | 154760 |
| 7 | Биндэр | 7 | 5 | | 1 | **13** | 377 | 75,0 | 1780 | 133500 | 13 | 1560 | 20280 | 153780 |
| 8 | Баян-Адрага | 5 | 4 | | 1 | **10** | 253 | 50,0 | 1760 | 88000 | 10 | 1580 | 15800 | 103800 |
| 9 | Норовлин | 7 | 6 | 18 | | **31** | 519 | 104,0 | 1770 | 184080 | 31 | 1630 | 50530 | 234610 |
| 10 | Батноров | | 38 | 3 | | **41** | 485 | 97,0 | 1760 | 170720 | 41 | 1570 | 64370 | 235090 |
| 11 | Баян-Овоо | 2 | 2 | 1 | 2 | **7** | 223 | 45,0 | 1770 | 79650 | 7 | 1650 | 11550 | 91200 |
| 12 | Мөрөн | 4 | 8 | | 8 | **20** | 373 | 74,0 | 1630 | 120620 | 20 | 1530 | 30600 | 151220 |
| **Дүн** | | **72** | **114** | **28** | **55** | **269** | **4897** | **977,0** | | **1665090** | **269** | | **414050** | **2079140** |

Аймгийн Засаг даргын 2017 оны 05 дугаар сарын 26 өдрийн A/206 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

# ГОЦ ХАЛДВАРТ, ХАЛДВАРТ ӨВЧНИЙ ГОЛОМТЫГ АРИУТГАЖ ХАЛДВАРГҮЙЖҮҮЛЭХЭД ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР, СУМААС ГАРАХ ЗАРДЛЫН НЭГТГЭЛ.

| № | Сумын нэр | Аймгаас ирэх очих, сум хооронд явах км | Ариутгах голомтын тоо | | | | | Сумаас гарах зардал | | | ХХААГазраас гарах зардал | | | Бүгд зардал | Нийт зардлын дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | Шаардагдах шатахуун /А-92 бензин / | | | Томилолт 2 хүн | | | | |
| | | | Бсом | Галзуу | Шүлхий | Хонины цэцэг | Бүгд | Нэг бүрийн үнэ | Хэмжээ /литр/ | Бүгд үнэ | Ажиллах хоног | Эмч /18000/ | Жолооч /12000/ | | |
| 1 | Баянхутаг | 22 | 8 | 17 | | 8 | 33 | 1700 | 4 | **6800** | 5 | 90000 | 60000 | **150000** | **156800** |
| 2 | Галшар | 125 | | 5 | 6 | 2 | 13 | 1710 | 25 | **42750** | 3 | 54000 | 36000 | **90000** | **132750** |
| | Чингис | 140 | | | | | | | 28 | **0** | | | | | |
| 3 | Мөрөн | 28 | 4 | 8 | | 8 | 20 | 1700 | 6 | **10200** | 2 | 36000 | 24000 | **60000** | **70200** |
| 4 | Жаргалтхаан | 70 | 6 | 10 | | 2 | 18 | 1670 | 14 | **23380** | 1 | 18000 | 12000 | **30000** | **53380** |
| 5 | Дэлгэрхаан | 45 | 18 | 12 | | 12 | 42 | 1540 | 9 | **13860** | 3 | 54000 | 36000 | **90000** | **103860** |
| 6 | Цэнхэрмандал | 70 | | 2 | | 13 | 15 | 1670 | 14 | **23380** | 2 | 36000 | 24000 | **60000** | **83380** |
| 7 | Өмнөдэлгэр | 135 | 15 | 5 | | 6 | 26 | 1720 | 27 | **46440** | 2 | 36000 | 24000 | **60000** | **106440** |
| 8 | Биндэр | 130 | 7 | 5 | | 1 | 13 | 1780 | 26 | **46280** | 2 | 36000 | 24000 | **60000** | **106280** |
| 9 | Баян-Адрага | 45 | 5 | 4 | | 1 | 10 | 1760 | 9 | **15840** | 1 | 18000 | 12000 | **30000** | **45840** |
| 10 | Норовлин | 80 | 7 | 6 | 18 | | 31 | 1770 | 16 | **28320** | 3 | 54000 | 36000 | **90000** | **118320** |
| 11 | Батноров | 100 | | 38 | 3 | | 41 | 1760 | 20 | **35200** | 3 | 54000 | 36000 | **90000** | **125200** |
| 12 | Баян-Овоо | 50 | 2 | 2 | 1 | 2 | 7 | 1770 | 10 | **17700** | 1 | 18000 | 12000 | **30000** | **47700** |
| 13 | Чингис | 145 | | | | | 0 | 1760 | 29 | **51040** | | 0 | 0 | **0** | **51040** |
| **Дүн** | | **1185** | **72** | **114** | **28** | **55** | **269** | | **237** | **361190** | **28** | **504000** | **336000** | **840000** | **1201190** |